

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ  
“АР НАЙМГАН” НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

*Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-004411  
Регистрийн дугаар:6268048*

**Хянасан:**

БОАЖЯ-ны ХБОБНУГазрын мэргэжилтэн: .....Ц.Жаргалнэмэх

Төв аймгийн БОАЖГазрын мэргэжилтэн: .....С.Эрдэнэцогт

**Биелэлтийг тайлагнасан:**

“Топ Ган Дриллинг” ХХК-ний захирал:.....П.Ганболд

“Топ Ган Дриллинг” ХХК-ний байгаль орчны мэргэжилтэн:.....Н.Гончигмаа

## Агуулга

<b>1. ОРШИЛ</b> .....	5
<b>2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b> .....	5
<b>3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	11
3.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ .....	11
3.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	14
3.3. Газрын хэвлийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт.....	18
3.4. Ургамал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах аргууд.....	19
<b>4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	20
<b>5. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> 31	
<b>6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	33
<b>7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	33
<b>8. ХИМИЙН БОДИС, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	33
<b>9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	33
<b>10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ</b> .....	38
<b>11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	39
<b>12. ДҮГНЭЛТ</b> .....	40

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ  
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

***Зургийн жагсаалт***

Зураг 1 Талбайн байршлын тойм зураг .....	6
Зураг 2 Ажилчдын хотхон орчмын төлөв байдал .....	8
Зураг 3 Уурхайн ажилчдын хотхон .....	8
Зураг 4 Захиргааны гадна талбай.....	9
Зураг 5 Ногооны талбай болон хүлэмж .....	9
Зураг 6 Орд орчмын төлөв байдал.....	10
Зураг 7 Усалгааны ажил хийгдэж буй байдал .....	12
Зураг 8 Карерийн зам талбай усалсан байдал.....	12
Зураг 9 Уурхайн тээврийн зам тоосжилтын хэмжилт .....	13
Зураг 10 Карерь дахь тоосжилтийг хэмжиж буй байдал .....	13
Зураг 11 Эрчим хүчний хэмнэлт хийе.....	14
Зураг 12 Хурдны хязгаарын тэмдэгнүүд.....	14
Зураг 13 Цэврийн нуурнаас дээж авч буй байдал .....	15
Зураг 14 Бохирын нуурнаас дээж авч буй байдал.....	15
Зураг 15 Усны зөв зохистой хэрэглээ брошур.....	15
Зураг 16 Булаг хамгаалах ажил эхлэхээс өмнө.....	16
Зураг 17 Булаг хамгаалах ажлын дараа.....	16
Зураг 18 Булаг хамгаалах ажлын явц .....	17
Зураг 19 Бэлэн болсон хашаа .....	17
Зураг 20 Шимт хөрсний овоолго ба Шимт хөрснөөс дээж авч буй байдал.....	18
Зураг 21 Засварын талбай болон ШТС-ийн орчмоос хөрсний дээж авч буй байдал.....	19
Зураг 22 Тос, масло солих газрын хөрсийг хамгаалсан байдал .....	19
Зураг 23 Сургалтын явц.....	20
Зураг 24 Дотоод овоолго үүсгэх замаар нөхөн сэргээлтийн ажил хийгдэж буй байдал .....	21
Зураг 25 Ухшийг дүүргэх, хурдас чулуулгийн овоолгыг намсгах, ирмэгийг налуулах, тэгшлэх, хэлбэршүүлэлтийн ажил явагдаж байна. ....	22
Зураг 26 Шимт хөрсний хучилтын ажил буюу Шимт хөрс дэвссэн байдал.....	23
Зураг 27 Үрийн холимог бэлтгэж буй байдал .....	24
Зураг 28 Үрэлгээ хийсэн трактор болон үрийн холимог жигд урсаж буй байдал .....	24
Зураг 29 Үрэлгээ хийж буй байдал.....	25
Зураг 30 Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн төлөв байдал.....	26
Зураг 31 Нөхөн сэргээсэн талбай дахь ургамалжилтийн мониторинг хийж буй байдал .....	26
Зураг 32 Ашиглалтын талбай дахь 5400 ш хайлаас тарьсан талбай.....	27
Зураг 33 Тарилтын дараах ургалтын төлөв байдал.....	28
Зураг 34 Хайлааст багт 1600 ш мод тарьсан талбай, ургалтын төлөв байдал .....	29
Зураг 35 Тарилтын дараах арчилгаа, усалгааг тогтмол хийсэн .....	30
Зураг 36 Дүйцүүлэн нөхөн сэргээлт хийсэн талбай.....	31
Зураг 37 Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн явц.....	31
Зураг 38 Дүйцүүлэн нөхөн сэргээлт эхлэхээс өмнө.....	32
Зураг 39 Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн ажил дууссаны дараа.....	32
Зураг 40 Ахуйн шингэн хаягдал боловсруулах танк суурьлуулалтын ажил .....	34
Зураг 41 Хог хаягдлын сургалтын явц .....	35
Зураг 42 Хогийн сав- хогоо ялган ангилсан байдал .....	35
Зураг 43 Ялган ангилалт хийсэн хуванцар хаягдлаа боловсруулах хувь хүнд хүлээлгэн өгсөн байдал .....	35

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ  
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

---

Зураг 44 Тамхий татах цэг, тамхины ишны хаягдал цуглуулах хэсэг.....	36
Зураг 45 Тамир-ЭМ бэлдмэлийг хэрэглэх заавар.....	37

***Хүснэгтийн жагсаалт***

Хүснэгт 1 Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбилцол .....	5
Хүснэгт 2 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт.....	11
Хүснэгт 3 Усан орчны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт.....	14
Хүснэгт 4 Газрын хэвлийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт.....	18
Хүснэгт 5 Ургамал амьтны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт.....	19
Хүснэгт 6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө болон биелэлт .....	33
Хүснэгт 7 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө болон биелэлт .....	39
Хүснэгт 8 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал.....	39

***Хавсралтын жагсаалт***

Хавсралт 1 Агаарын чанарын шинжилгээ дүн (6 сар).....	41
Хавсралт 2 Агаарын чанарын шинжилгээ дүн (8 сар).....	42
Хавсралт 3 Ус ашиглах зөвшөөрөл .....	43
Хавсралт 4 Ус ашиглах гэрээ .....	44
Хавсралт 5 Усны төлбөр төлсөн баримт.....	47
Хавсралт 6 Гүний худгийн усны дээж /шүлтүүргүй/ шинжилгээ MNS 0900:2018 (6 сар).....	48
Хавсралт 7 Унд ахуйд хэрэглэж буй усны шинжилгээ дүн MNS 0900:2018 (6 сар).....	49
Хавсралт 8 Технологийн бохирын нуур дээж шинжилгээний дүн /6 сар/.....	50
Хавсралт 9 Технологийн цэврийн нуур дээж шинжилгээний дүн /6 сар/.....	51
Хавсралт 10 Худгийн ус болон филтергүй усны шинжилгээ дүн MNS 0900:2018 (8 сар) .....	52
Хавсралт 11 Бохир болон цэврийн нуурны шинжилгээний дүн MNS 4943:2015 (8 сар).....	54
Хавсралт 12 Газар ашиглалтын гэрээ.....	55
Хавсралт 13 Газрын төлбөр төлсөн баримт.....	56
Хавсралт 14 Дүйцүүлэн нөхөн сэргээлт хийсэн талбай хүлээлцсэн акт.....	57
Хавсралт 15 Нөхөн сэргээлтийн барьцаа төлбөр төлсөн баримт .....	58
Хавсралт 16 Шимт хөрсний дээж шинжилгээний дүн /6 сар/.....	61
Хавсралт 17 Шимт хөрс болон нөхөн сэргээлтийн талбайн хөрсний шинжилгээ дүн (8 Сар).....	62
Хавсралт 18 Хог хаягдал гэрээ.....	63
Хавсралт 19 Хог хаягдлын төлбөр төлсөн баримт.....	65
Хавсралт 20 Хаягдал усны гэрээ.....	66
Хавсралт 21 Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл.....	68
Хавсралт 22 Хаягдал ус гэрээний төлбөр төлсөн баримт.....	69
Хавсралт 23 Булгийн эх хамгаалалтын ажил хүлээлцсэн акт.....	70

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ  
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**1. ОРШИЛ**

Манай компани нь байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах, байгалийн унаган төрхийг аль болох хадгалах, биологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу өндөр түвшинд хийж гүйцэтгэх бодлого баримталж, байгаль орчны бодлого зорилгод нийцсэн арга хэмжээнүүдийг авч, биелэлтийг ханган ажилладаг. Үүнд:

- ☆ Байгаль орчны бохирдолтоос сэргийлэх, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах сөрөг нөлөөллийг тодорхойлж, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг авах зорилгоор байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хийлгүүлэх
- ☆ Байгаль орчныг хамгаалах тухай хууль, тогтоомж холбогдох дүрэм журам стандартыг дагаж ажиллах
- ☆ Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэхдээ биологийн нөхөн сэргээлтийн ажлын үр дүнд тавих үндсэн шаардлага, байгалийн үндсэн бүсээс хамаарах агротехникийн шаардлага, ургамлын нөхөн сэргээлтийн үе шатууд, тарих ургамлуудыг сонгох болон нөхөн сэргээсэн газрыг хүн, мал, салхи, усны нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах, нөхөн сэргээж буй газрын хөрс, ургамлын хяналт шинжилгээнд тавих шаардлагын дагуу хийж гүйцэтгэх
- ☆ Олборлолт болон уурхайн үйл ажиллагааны бүхий л үе шатанд байгаль орчны асуудлыг тусган хэрэгжүүлэх хамаарна.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан нь тус оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний заалтуудыг ханган ажиллахад чиглэсэн болно.

**2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**


Ар Наймган нэртэй MV-004411 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Улаанбаатар хотоос баруун хойш 230 км, Төв аймгийн Заамар сумын төвөөс баруун хойш 45 км, ”Шижир алт” суурингаас 1.5 км зайд орших ба талбайн булангийн цэгүүдийн газар зүйн солбилцолыг хүснэгтээр үзүүлэв. Бүс нутгийн хувьд Хэнтийн нурууны баруун хойд хэсэгт, Заамарын нуруу, Туул голын ай сав газарт, дэд бүтцийн тааламжтай нөхцөлд байрладагаараа онцлогтой.

*Хүснэгт 1 Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбилцол*

Д/д	Уртраг	Өргөрөг
1	104° 25' 33.63"	48° 18' 16.66"
2	104° 25' 28.1"	48° 18' 16.64"
3	104° 25' 0.93"	48° 18' 16.6"
4	104° 25' 0.93"	48° 17' 53.91"
5	104° 25' 24.94"	48° 17' 53.91"
6	104° 25' 24.94"	48° 17' 31.81"
7	104° 26' 56.74"	48° 17' 31.81"
8	104° 26' 56.78"	48° 18' 8.4"
9	104° 26' 54.94"	48° 18' 8.4"
10	104° 26' 55.04"	48° 18' 0.29"
11	104° 26' 44.75"	48° 18' 0.24"
12	104° 26' 44.78"	48° 17' 57.98"

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

13	104° 26' 35.74"	48° 17' 57.93"
14	104° 26' 35.69"	48° 18' 3.44"
15	104° 26' 26.86"	48° 18' 3.39"
16	104° 26' 26.84"	48° 18' 4.88"
17	104° 26' 12.67"	48° 18' 4.81"
18	104° 26' 12.63"	48° 18' 8.7"
19	104° 25' 33.71"	48° 18' 8.5"



*Зураг 1 Талбайн байршлын тойм зураг*

**Уул зүй:** Төв аймгийн Заамар сумын нутаг дэвсгэр нь Хангай Хэнтийн уулархаг их мужид хамрагдана. Хангай-Хэнтийн их мужийн уулс голдуу налуу хажуутай тул хөрсөн бүрхэвч бүрэлдэн тогтоход тааламжтай нөхцөлийг бий болгодог.

**Ус зүй:** Ар наймганы алтны шороон ордын талбай нь гидрогеологийн ангиллаар Хангай, Хэнтийн гидрогеологийн массивт хамаарна. Газрын доорх ус нь уулс хоорондын хөндийнүүдийг дүүргэсэн тунамал хурдас болон дунд ба эрт төрмөлийн гүний ба тунамал-метаморф чулуулгийн ан цавтай холбоотой. Газрын доорх усны түвшин газрын гадаргаас 42-44 м гүнд оршино. Ар наймганы хэмжээнд усны байгалийн нөөц 1448-1933 шоо метр хоног байна. Дөрөвдөгчийн аллювийн хурдсан дах гүний ус нь цэнгэг бөгөөд эрдэсжилт нь 0.4 г/л-с илүүгүй, устөрөгчийн ионы концентраци буюу рН 7.5-8.5, ерөнхий хатуулаг 4.3 мг.экв. Газрын доорх ус нь найрлагаараа ундны усны шаардлагыг бүрэн хангана. Туул голын газрын доорх ус нүүрхүчлийн хий болон хүчил, сульфат, магнийн зэрэг идэмхий агуулагчгүй учир гидрогеологийн нөхцөлийн хувьд энгийн нөхцөлтэйд тооцогдоно /Хишигтогтох, 2013/.

**Уур амьсгал:** Уур амьсгалыг бүрдүүлэгч олон хүчин зүйлсийн дотроос нарны цацраг, агаарын орчил урсгал, байгалийн газарзүйн нөхцөл чухал юм. Эдгээрийн харилцан үйлчлэлийн нөлөөгөөр тухайн газар орны уур амьсгалын нөхцөл бүрэлдэн тогтоно. Төв аймаг уур амьсгалын хувьд сэрүүвтэр, хуурай дулаавтар, мужид багтана.

☆ **Заамар сумын уур амьсгал, цаг уурын үзүүлэлтүүд**

Төсөл хэрэгжих орчны цаг уур, уур амьсгалын үндсэн үзүүлэлтийг Төв аймгийн Заамар сумын цаг уурын “ЗААМАР” харуулын сүүлийн 10 жилийн мэдээний үндсэн дээр тодорхойлсон болно.

**Агаарын температур:** Агаар мандлын дулааны горим бол агаар мандал дахь температурын хуваарилалт, хувьсал өөрчлөлтийн явцаар тодорхойлогдох бөгөөд энэ нь тухайн газар нутгийн уур амьсгалын үндсэн элемент болж агаар, хүрээлэн буй орчны хоорондох дулааны солилцоогоор илэрдэг зүй тогтолтой. 2009-2019 оны агаарын жилийн дундаж температур - 0.7-2.3<sup>0</sup> байна.

**Хөрс, ургамал:** Төсөл хэрэгжих бүс нутаг нь хөрс газар зүйн ангиллын хувьд Хангайн хөрсний их муж түүн дотор Хангайн мужид тус тус хамаарна. Хангайн их мужид хамгийн түгээмэл тархсан хөрс бол хээрийн хүрэн хөрс бөгөөд орон нутгийн хөрс үүсэх өөр өөр нөхцөлөөс шалтгаалж хүрэн хөрсний хэд хэдэн дэд хэв шинж хар хүрэн, хүрэн, цайвар хүрэн, уулын хүрэн, нугын хүрэн, ойн хүрэн хөрс тус тус тархсан байна /Доржготов, 2003/

**Хүн ам, эдийн засаг:**

Төв аймгийн Заамар сум нь хүн амын суурьшил ихтэй бүс нутаг бөгөөд сумын хэмжээнд 3000 орчим хүн амтай. Халх ястан голлон амьдардаг. Голчлон газар тариалан, мал аж ахуй эрхэлдэг. Заамар район нь зам харилцаа сайтай өвөл, зуны аль ч улиралд бартаа саадгүй, аж үйлдвэр, ХАА-н үйлдвэрлэлийн баазуудад ойр байрлана.

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМ1Н НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ  
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

---



*Зураг 2 Ажилчдын хотхон орчмын төлөв байдал*



*Зураг 3 Уурхайн ажилчдын хотхон*



ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ  
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



*Зураг 4 Захиргааны гадна талбай*



*Зураг 5 Ногооны талбай болон хүлэмж*



*Зураг 6 Орд орчмын төлөв байдал*

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ  
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТ**

“Топ Ган Дриллинг” ХХК нь байгалийн баялгийг ашиглаж, үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд оршин буй нутгийн байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагааныхаа нэг хэсгийг чиглүүлэх үүрэгтэй.

*3.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ*

*Хүснэгт 2 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт*

№	Төлөвлөгөө	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Уурхайн тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэлд утааны шүүлтүүрүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, тос малыг тогтоосон хугацаанд нь солих	Уулын мастер, ахлах механик	250 мот/цаг тутамд тээврийн хэрэгслүүдийн тос, малыг сольж байсан. Техник тоног төхөөрөмжийн үзлэг, шалгалтыг тогтмол явуулж, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж гүйцэтгэсэн.
2.	Агаарын тоосжилтыг бууруулах зорилгоор дотоод тээврийн замыг тогтмол услах		Автозам ба овоолго, ажлын талбайг тогтмол услан, засч, тэгшилж ажилласан.
3.	Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлэх	Уурхайн дарга	Хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан агаарын шинжилгээг хийлгэсэн ба шинжилгээний дүнг хавсаргав.
4.	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө.		Тээврийн хэрэгслийн төлбөр, татварыг бүрэн төлж ажилласан.
5.	Эрчим хүчийг хэмнэх үйл ажиллагаа	Байгаль орчны мэргэжилтэн, ХАБЭА-н инженер	Ажилчдад эрчим хүч дэлхийн дулаарлын талаар нөлөөлөх, сургалтуудыг орж, ажилчдын амрах 50 өрөө, 5 захиргааны байруудад брошур байрлуулсан. Ажилчдын байр дахь гэрлүүдийг LED гэрлээр сольж, Дизель генераторын үр ашиггүй хэрэглээг хянан ажилласан байна.
6.	Замаас үүсэх тоосжилтыг бууруулахын тулд хурдны хязгаарыг баримтлуулах		Уурхайн талбай доторх замуудад нэмэлтээр хурдны хязгаарын 5, 20, 40, тэмдгүүдийг байрлуулсан. Туршилтаар 15 тээврийн хэрэгсэлд хурд, байршлыг хянах зорилгоор GPS суурьлуулан хянан ажиллаж байна.




*Зураг 7 Усалгааны ажил хийгдэж буй байдал*



*Зураг 8 Карерийн зам талбай усалсан байдал*




*Зураг 9 Уурхайн тээврийн зам тоосжилтын хэмжилт*



*Зураг 10 Карерь дахь тоосжилтийг хэмжиж буй байдал*

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ  
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



*Зураг 11 Эрчим хүчний хэмнэлт хийе*



*Зураг 12 Хурдны хязгаарын тэмдэгнүүд*

**3.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ**

Усны нөөцийг хамгаалах үүднээс технологит ашиглах усны хэмжээг бага байлгах үүднээс анхаарч ажилласан. Баяжуулах буюу элстэй шороог угаахад хэрэглэж буй усыг 30%-ийг сэлбэн 70%-ийг эргүүлэн ашигласан.

*Хүснэгт 3 Усан орчны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт*

№	Төлөвлөгөө	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Сав газартай гэрээ байгуулан ус ашиглах дүгнэлт гаргуулах	Компаний захирал	Сав газартай байгуулсан гэрээ болон ус ашигласан төлбөр төлсөн баримтаа хавсаргав.
2.	Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх	Байгаль орчны мэргэжилтэн	Шинжилгээний хариу шалгуур үзүүлэлт нь хавсралтад тусгагдав.
3.	Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох бохирдохоос сэргийлэх		Орон нутгийн байгаль хамгаалагчаас санал авч сэргээн засварлах шаардлагатай Ар уртын булгийн эхийг хашаалан, хамгаалах ажлыг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Мөн ажилчдад усны нөөц, түүний хэрэглээний талаар сургалт, танилцуулга бэлтгэн хүргэсэн.

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМ1Н НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ  
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



*Зураг 13 Цэврийн нуурнаас дээж авч буй байдал*



*Зураг 14 Бохирын нуурнаас дээж авч буй байдал*



*Зураг 15 Усны зөв зохистой хэрэглээ брошур*

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМ1Н НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ  
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

---

Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох бохирдохоос сэргийлэх ажлын хүрээнд орон нутгийн байгаль хамгаалагчаас санал авч сэргээн засварлах шаардлагатай Ар уртын булгийн эхийг хашаалан, хамгаалах ажлыг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Булгийн эхийг хашиж хамгаалах нь усны ундаргыг хамгаалаад зогсохгүй, булаг орчмын экосистем, усны орчныг бүхэлд нь бохирдол, талхагдлаас хамгаалах ач холбогдолтой.



*Зураг 16 Булаг хамгаалах ажил эхлэхээс өмнө*



*Зураг 17 Булаг хамгаалах ажлын дараа*





*Зураг 18 Булаг хамгаалах ажлын явц*



*Зураг 19 Бэлэн болсон хашаа*

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ  
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

*3.3. Газрын хэвлийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт*

*Хүснэгт 4 Газрын хэвлийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт*

<b>№</b>	<b>Төлөвлөгөө</b>	<b>Хариуцах эзэн</b>	<b>Биелэлт</b>
1.	Газар эзэмших гэрээгээ Заамар сумын ЗД-тай байгуулах, төлбөрөө төлөх	Компанийн захирал	Гэрээ болон төлбөр төлсөн баримтаа хавсаргав.
2.	5.2 га талбайд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийх	Байгаль орчны мэргэжилтэн, уулын мастер	Нөхөн сэргээлтээ сум орон нутагт хүлээлгэн өгсөн тухай акт хавсаргав.
3.	Хуулсан шимт хөрсийг хадгалж хамгаалах	Байгаль орчны мэргэжилтэн	Шимт хөрсийг хэлбэршүүлэн хадгалсан бөгөөд 2022 онд шимт хөрсийг ашиглах учраас ургамалжуулах ажил хийгдээгүй.
4.	Засварын газраас өөр газарт тос, масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг элс асгаж, саармагжуулах	Байгаль орчны мэргэжилтэн	Засварын талбайгаас өөр газарт тос, масло асгарсан тохиолдол бүртгэгдээгүй
5.	Тоног төхөөрөмжийн тос масло солих газрын хөрсийг хамгаалах	Байгаль орчны мэргэжилтэн	Хөрс хамгаалах талбайг бэлтгэн, асгаралтын үед шаардагдах элс, шингээгч материалуудыг ойр байршуулсан.



*Зураг 20 Шимт хөрсний овоолго ба Шимт хөрснөөс дээж авч буй байдал*

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМИН НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ  
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



*Зураг 21 Засварын талбай болон ШТС-ийн орчмоос хөрсний дээж авч буй байдал*

<p align="center"><b>1</b></p>		
<p align="center"><b>4</b></p>	<p align="center"><b>5</b></p>	<p><b>1.</b> Засварын талбайд ашигласан тос, маслыг хадгалах 15 м<sup>2</sup> бүхий талбайг бэлтгэсэн.</p> <p><b>2.</b> Ашиглагдсан тос, масло хөрсөнд нэвчин гүний ус, уст давхаргыг бохирдуулах болзошгүй сөрөг нөлөөллөөс сэргийлэхийн тулд доторжуулан тусгаарлагч материалыг дэвсэж байна.</p> <p><b>3. 4.</b> Гадаргуу дээрээ бохирдуулагчийг шингээгч материал болох нарийн ширхэг бүхий эфилиэр гадаргууг бүрхэн тэгшилсэн.</p> <p><b>5.</b> Бэлэн болсон ашигласан тос, масло хадгалах цэг</p>

*Зураг 22 Тос, масло солих газрын хөрсийг хамгаалсан байдал*

*3.4. Ургамал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах аргууд  
Хүснэгт 5 Ургамал амьтны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт*

№	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Олон салаа зам гаргахгүй байх	Уурхайн дарга,	Өглөө бүрийн ажлын зааварчилгаанд заавар өгдөг.

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ  
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

		Байгаль орчны мэргэжилтэн	Уурхайн бүсэд мөрдөх байгаль орчны 7 дүрэм, зарчмыг боловсруулан, даган мөрдүүлэх тал дээр ажиллаж байна.
2.	Нөхөн сэргээлт хийсэн талбайд ургамлын бичиглэл хийнэ.	Байгаль орчны мэргэжилтэн	Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайдаа ургамлын бичиглэлийг хийсэн.
3.	Цөлжилтөөс хамгаалах ойн тухай хуулийн дагуу уурхайн ашиглалтын талбайд тарьсан модоо арчлах хамгаалах	Компанийн захирал	Өвлийг давж чадаагүй суулгацуудыг хаяж, эрүүл ургаж буй модоо арчлан хамгаалсан.



Зураг 23 Сургалтын явц

#### 4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 оны уулын ажлын төлөвлөгөөний **11.3 га** талбайд уулын ажил явагдахаар төлөвлөөд байсан бол **19.8 га** талбайд уулын ажил явагдсан. Уурхайн ашиглалтын ажил явагдаж байхад нөхөн сэргээлт буюу дүүргэлтийн ажлыг дотоод овоолгоор зэрэгцээ байдлаар хийдэг. Энэ нь нөхөн сэргээлтийн зардлыг багасгах болоод их хэмжээний гадаад овоолгыг үүсгэн, газрын эвдрэл үүсгэхгүй байх давуу талтай.

Дотоод овоолгоор олборлолт явуулсан талбайн **5.2 га**-д техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөөд байсан бол **8.03 га** талбайд техникийн нөхөн сэргээлт хийгдэж байна.

Биологийн нөхөн сэргээлтийг **2.0 га** талбайд хийхээр төлөвлөсөн бөгөөд 2022 оны эцэст **6.39 га-д** бэлчээрийн зориулалтаар олон наст ургамлуудаар тариалалт хийсэн ба ургамлын өсөлт, төлөв байдлыг харууллаа.

Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд 1000 ширхэг мод тарихаар төлөвлөөд байсан бол ашиглалтын 1.2 га талбайдаа **5400 ширхэг** 2-3 настай хайлаас модны суулгацаар тарилт хийж, арчлалт хамгаалалтын ажлыг хийсэн. Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд Заамар сумын Хайлааст багт нийтийн эзэмшлийн 0.5 га талбайд голт бор, шар хуйас, гүйлс, нохойн хошуу, хайлаас зэрэг 5 төрлийн **1600 ширхэг** гоёлын моддыг төв зам дагуу тарилт, хашаалалт хамгаалалт болон арчилгааны ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. 2022 онд нийтдээ 7000 ширхэг модны тарилтыг ажлуудыг хийж, сум орон нутагт хүлээлгэн өгсөн.



*Зураг 24 Дотоод овоолго үүсгэх замаар нөхөн сэргээлтийн ажил хийгдэж буй байдал*



*Зураг 25 Ухшийг дүүргэх, хурдас чулуулгийн овоолгыг намсгах, ирмэгийг налуулах, тэгшлэх, хэлбэршүүлэлтийн ажил явагдаж байна.*



Шимт хөрс тараахад бэлтгэсэн  
байдал



Шимт хөрс тараасан талбайн  
том чулууг түүж буй байдал

*Зураг 26 Шимт хөрсний хучилтын ажил буюу Шимт хөрс дэвссэн байдал*

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМ1Н НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ  
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



*Зураг 27 Үрийн холимог бэлтгэж буй байдал*



*Зураг 28 Үрэлгээ хийсэн трактор болон үрийн холимог жигд урсаж буй байдал*



ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМ1Н НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ  
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

---



*Зураг 29 Үрэлгээ хийж буй байдал*





*Зураг 30 Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн төлөв байдал*



*Зураг 31 Нөхөн сэргээсэн талбай дахь ургамалжилтийн мониторинг хийж буй байдал*

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМ1Н НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ  
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

---



*Зураг 32 Ашиглалтын талбай дахь 5400 ш хайлаас тарьсан талбай*



ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМ1Н НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ  
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг 33 Тарилтын дараах ургалтын төлөв байдал

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМ1Н НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



*Зураг 34 Хайлааст багт 1600 ш мод тарьсан талбай, ургалтын төлөв байдал*


ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг 35 Тарилтын дараах арчилгаа, усалгааг тогтмол хийсэн

**5. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТ**

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутгаас тогтоож өгсөн 10 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил хийж хүлээлгэн өгсөн.



*Зураг 36 Дүйцүүлэн нөхөн сэргээлт хийсэн талбай*



*Зураг 37 Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн явц*



*Зураг 38 Дүйцүүлэн нөхөн сэргээлт эхлэхээс өмнө*



*Зураг 39 Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн ажил дууссаны дараа*



**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ  
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй.

**7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2022 оны олборлолтын явцад ямар нэгэн түүх, соёлын дурсгалт зүйл олдоогүй болно.

**8. ХИМИЙН БОДИС, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТ**

2022 онд осол эрсдэлгүй ажилласан байна. Ажилчдын дунд “Тэг Осол эрсдэлгүй ажлын байр” нэртэй уралдааныг сар бүр зохион байгуулж байгаа бөгөөд ажлын хэсэг тус бүрээс шилдэг ажилчдыг урамшуулдаг. Хөдөлмөр аюулгүй байдлын сургалт, өдөр тутмын зааварчилгааг ХАБ хариуцсан мэргэжилтэн өгч байгаа билээ.

Мөн төсөл хэрэгжих шороон ордын ашиглалтын явцад химийн тэсэрч дэлбэрэх химийн бодис ашиглаагүй.

**9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Үйл ажиллагааны явцад гарах ахуйн хог хаягдлыг Заамар сумтай гэрээ байгуулан тээвэрлүүлсэн. /Төлбөр төлсөн баримт хавсаргав/ Мөн байгальд шууд хаягдах хаягдлын хэмжээг багасгахын тулд эх үүсвэр дээр нь ялган ангилалт хийх хогийн савыг уурхайн хотхон байрлуулан, ялган ангилалт хийж, ажилчдад хог хаягдлын хор уршиг болон ялган ангилалтын үр ашгийн талаарх сургалтуудыг орсон.

*Хүснэгт 6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө болон биелэлт*

№	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Зарим хаягдлыг нэгдсэн журмаар сумын хогийн цэгт хаях	Компанийн захирал	Засаг даргатай хийсэн гэрээг хавсралт хэсэгт оруулав.  Төлбөр төлсөн баримт хавсаргав.
2.	Ахуйн хог хаягдлаа эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан тээвэрлүүлнэ.		
3.	Хог хаягдлын төлбөрөө төлөх		
4.	Ахуйн шингэн хаягдал гүний усыг бохирдуулж байгаа эсэхэд бохир усны химийн шинжилгээ хийлгэх, ахуйн бохирын татуургыг доторжуулах	Байгаль орчны мэргэжилтэн	Хяналт шинжилгээний ажлаар гүний худагнаас усны дээж авч шинжилгээнд өгсөн ба шинжилгээний дүнг хавсралтад оруулав.  Хаягдал усны гэрээ, дүгнэлтийг гаргуулсан бөгөөд хаягдал ус зайлуулах зөвшөөрөлтэй.

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ  
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

			Ахуйн шингэн хаягдал цэвэршүүлэх танк байрлуулсан
5.	Ахуйн бохир ариутгах, халдваргүйжүүлэх, задлах бодис худалдан авах	Байгаль орчны мэргэжилтэн	Ахуйн бохироо Тамир-ЭМ бэлдмэлээр ариутган халдваргүйжүүлэн, задалдаг.
6.	Уурхайн техникт ашигласан тос, маслыг хаягдал тос боловсруулах үйлдвэрт нийлүүлэх		Одоогоор хаягдал тосыг цуглуулах ажил хийгдэж байгаа бөгөөд “Алтан Оршихуй” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.
7.	Ахуйн хатуу хог хаягдлаа ангилах хогийн савнуудыг байрлуулах		Уурхайн хотхонд хуванцар сав, шил болон лааз, цаасан хаягдлуудыг ялгах тасалгаа бүхий тагтай сав хаягдал төмөр ашиглан хийж, байрлуулсан.
8.	Хаягдлаас гарах дахин ашиглагдах түүхий эдийг ялгах		Ялган ангилаад хурааж байна.



*Зураг 40 Ахуйн шингэн хаягдал боловсруулах танк суурьлуулалтын ажил*

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг 41 Хог хаягдлын сургалтын явц



Зураг 42 Хогийн сав- хогоо ялган ангилсан байдал



Зураг 43 Ялган ангилалт хийсэн хуванцар хаягдлаа боловсруулах хувь хүнд хүлээлгэн өгсөн байдал

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хүрээлэн буй орчны бохирдлыг багасгах зорилгоор аймгийн Засаг даргын 2022 оны А/492 дугаар захирамжийг мөрдөн “Аюулыг авдарлая” тамхины иш цуглуулах ажлын хүрээнд кемп, засварын талбай болон гал тогоо орчим хүн ихээр цугларах талбайд тамхи татах цэгийг үүсгэн ажилласан.

Тамхины иш нь хөрс, ус, ургамалд нэвчсээр хүний эрүүл мэндэд нөлөөлж харшил, хавдар зэрэг олон өвчний суурь шалтгаан болж, байгальд 12 жилийн дараа бүрэн задардаг, хэт нарийн ширхэгтэй хуванцар болох талаар танилцуулан ажилласан.



*Зураг 44 Тамхи татах цэг, тамхины ишны хаягдал цуглуулах хэсэг*

Ажилчдын шингэн хог хаягдлыг ариутгах журмаар “Тамир-ЭМ” бэлдмэлийг ашигласан бөгөөд уурхайн үйлчлэгчид хэрэглэх зааварчилгааг хүргэсэн.

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ  
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Ил задгай жорлон, бохирын цэвэрлэгээнд 1-2л Тамир-ЭМ-ийг жил бүрийн хавар 5-6 сард, гун 8-9 сард 2 удаа хийнэ. Ингэснээр үнэрийг дарж, бохирыг ширгээж, ялгадсыг био ялзмаг болгон хөрсийг эрүүлжүүлэн 00-ын эдлэх хугацааг уртасгадаг.

**Тамир био бэлдмэлийг ашиглах заавар:**

- Ашиглахаас өмнө сайтар сэгсэрнэ.
- 1 м3 жорлонгийн агууламжинд 1 литр Тамир ариутгагч байхавар тооцож 8-10 литр хлоргүй бүлээн усанд шингэлж жорлонгийн нүхний нэг булан руу цутгана.
- Хэрэв жорлонгийн бохир ус ихтэй бол Тамир био ариутгагчийг усаар шингэлэхгүйгээр шууд нэг булан руу нь цутгана.

**АНХААРААРАЙ:** Хлор нь амьд биетийг устгагч хорт бодис тул био бэлдмэлийг шингэлэхдээ хлортой ус ашиглавал бэлдмэлийн үйлчилгээнд муу нөлөөтэй. Ус нь хлортой байх магадлалтай тул усав саванд хийж 2 хоног хонуулахад хлор нь ууршиж алга болно. Ингэж хлоргүйжсэн усыг био бэлдмэл шингэлэхдээ ашиглаарай.

*Зураг 45 Тамир-ЭМ бэлдмэлийг хэрэглэх заавар*

Уурхайн эмнэлгээс гарах аюултай хаягдлыг Заамар сумын Эрүүл Мэндийн төвд нийлүүлэн, хамтран ажиллах гэрээ байгуулан тогтсон хугацаанд хаягдлыг хүргэж, хаягдлыг бүрэн зайлуулах хүртэл аюулгүй нөхцөлд түр цуглуулан, хаягдалд хяналт тавин ажиллаж байна.

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ**

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тус оны 5 болон 8 дугаар саруудад Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэсэн “Ногоон Эко Мандала” ХХК-аар хийлгүүлсэн. Тус хөтөлбөрийн хүрээнд хөрс, уснаас дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлж мөн агаар дахь тоосжилтын хэмжээ болон дуу, чимээ, харьцангуй чийгшил зэрэг үзүүлэлтүүдийн хэмжилтийг хийсэн.

Хяналт шинжилгээний дээж	Хяналт шинжилгээний үзүүлэлт	2022 оны хяналт шинжилгээний хэлбэр, зардал	Хяналт шинжилгээ явуулах хугацаа	Хяналт шинжилгээ явуулах байршил	Хяналт шинжилгээ хийх багаж, холбогдох стандарт
<b>Агаар</b>	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> CO -ын агууламж, дуу чимээ	Агаарын шинжилгээний 3 цэгт жилд 2 удаа хэмжилт хийлгэнэ.	Жил бүрийн 5 болон 8 дугаар саруудад	Уурхайн карьер, Уурхайн зам, Ажилчдын хотхон	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар-хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2016
<b>Ус</b>	Ажилчдын унд ахуйд ашигладаг усыг бактериологи болон ундны усны ерөнхий шаардлага, цэврийн болон бохирын нуурын усыг гадаргын ус болон хүнд металлын шинжилгээнд өгөх	Унд ахуйн ус Бактериологи Усны химийн ерөнхий шинжилгээ Цэврийн болон бохирын нуур Хүнд металл	Жил бүрийн 5 болон 8 дугаар саруудад	Унд ахуйн усны гүний худаг, цэврийн болон бохирын нуур	Усны тухай хууль, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус, Ерөнхий шаардлага MNS 4943:2015, Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2018, Байгаль орчны аялал жуучлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2018 оны 04 сарын 05 өдрийн А82/128 тоот тушаалын хавсралт. Ахуйн хаягдал ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам
<b>Хөрс</b>	Хөрсний агрохими болон хүнд металлын шинжилгээ хийлгэх мөн тухайн газар дээр хөрсний температур хэмжих	Шимт хөрсний овоолго Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай Засварын талбай Шатахуун түгээх газар	Жил бүрийн 5 болон 8 дугаар саруудад	Уурхайн шимт хөрсний овоолго, ахуйн бохир усны хаягдал орчимд, нөхөн сэргээсэн талбай, эвдрээгүй газар	MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр. төрөл MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох MNS2305-94 Дээж авах. савлах. тээвэрлэх. хадгалах журам MNS(ISO) 4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ  
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Уурхайн үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцаж ажиллана.

*Хүснэгт 7 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө болон биелэлт*

№	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Компанийн захирал Байгаль орчны мэргэжилтэн	Байгаль орчны бодлого хөтөлбөр, хяналт шинжилгээ хийх журам, хог хаягдлын цуглуулах, хадгалах ажлын тухай заавар журмуудыг захирлаар батлуулж, ажилчдад танилцуулан дагаж мөрдөн ажиллаж байна.
2.	Уурхайн үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжилтэнгүүдийг газар дээр нь танилцуулна.		Заамар сумын Хайлааст багийн иргэдийн нийтийн хуралд уурхайн үйл ажиллагаа, нөхөн сэргээлтийн талаар илтгэл хэлэлцүүлсэн.
3.	Техник болон биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайг сум орон нутаг болон улсын комисст хүлээлгэн өгөх		Улсын комисст хүлээлгэн өгсөн актыг хавсралтад оруулав.
4.	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ болон Заамар сумын ЗДТГ-т хүргэн өгч байх		Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан болон тус оны нөхөн сэргээлт, нийгмийн хариуцлагын тайланг хүргэн танилцуулдаг.

*Хүснэгт 8 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал*

Д.д	Зардлын утга	Нийт зардал, мян.төг
1	Ус ашиглах зардал	60403.8
	<b>2022 онд ашигласан усны төлбөр</b>	<b>60403.8</b>
1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	2000.0
2	Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	1500.0
3	Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	500.0

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ  
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

4	Хог хаягдлын менежментээр хийгдсэн ажлын зардал	1000.0
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	500.0
6	Нөхөн сэргээлтийн ажлын зардал	5500.0
7	Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн зардал	5000.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	1498.8
9	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	1000.0
	<b>2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн</b>	<b>18498.8</b>

## 12. ДҮГНЭЛТ

2022 оны уулын ажлын төлөвлөгөөний дагуу 19.8 га талбайд уулын ажил явагдсан. Дотоод овоолгоор олборлолт явуулсан талбайн 5.2 га-д техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөөд байсан бол 8.03 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийгдсэн байна.

Биологийн нөхөн сэргээлтийг 6.39 га-д бэлчээрийн зориулалтаар олон наст ургамлуудаар тариалалт хийсэн байна.

2022 оны байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг 05 болон 08-р саруудад байгаль орчны үнэлгээ, зөвөлгөөний эрх бүхий байгууллага “Ногоон Эко Мандала” ХХК-аар хийлгэн гүйцэтгүүллээ. Энэхүү хяналт шинжилгээний хүрээнд уурхайн технологийн ус болон цэвэр усны нууранд гадаргын усны чанар стандартад нийцэж байгаа эсэхэд бохирын нуурын усанд хүнд металлын үзүүлэлт, агууламж хэдий хэмжээтэй байгааг итгэмжлэгдсэн лабораториудад дээж өгч шинжлүүлэн өмнөх сарын үр дүнтэй харьцуулж үзсэн. Тус шинжилгээний дүнгээр цэвэр нуурын ус гадаргын усны стандартад шаардлагын түвшинд, бохирын нуурын хүнд металлын агуулга стандартаас хэтрээгүй үзүүлэлттэй байсан. Уурхайн засварын газар, ШТС-ын ойролцоо газрын хөрсөнд хүнд металлын шинжилгээ хийлгэсэн бөгөөд стандарт түвшинд байна.

Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд сум орон нутагт эзэнгүй орхигдсон 10 га талбайд дүйцүүлэн техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж, Заамар сумын Ар уртын булгийг эхийг тохижуулан, хашаалан хамгаалалтын ажлыг гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.

Хайлааст багийн төвд 0.5 га талбайд “Бага Хаян” ТББ мод тарилт хийж, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байгууллагатай хамтран 1600 ширхэг гоёлын шар хуйас, голт бор, гүйлс болон нохойн хошуу зэрэг моддыг тарилт хийсэн ба ашглалтын талбайдаа 5400 ширхэг хайлаас мод тарьсан.

Уурхайн ус ашиглах гэрээг Туул голын сав газартай байгуулан 60,403,881.0 төгрөг тушаасан болно. Мөн хаягдал усны дүгнэлт гаргуулж 2022 оны ус ашиглуулах дүгнэлтэд үндэслэн усанд нийт 597,300.0 төгрөг төлсөн.



**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ  
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818  
E-mail: [bohzi@gmail.com](mailto:bohzi@gmail.com)



**СОРИЛТЫН ДҮН**

Дугаар он/№ : 2022/А-164  
 Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Топ Ган Дриллинг"ХХК  
 Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : Б.Батхшиг агаарын хэсэг  
 Дээжийн тоо, төрөл : 4 агаар, 4 дуу чимээ  
 Сорьц авсан огноо : 2022.06.12  
 Дээжийн тодорхойлолт : Төв аймаг, Заамар сум  
 MV-004411 ашигт малтмалын талбай  
 Шинжилгээний аргын стандарт : MNS 0017-2-5-12:2021, MNS 0017-2-5-11:2021  
 CA3 A07-2016  
 Шинжилсэн огноо : 2022.06.20  
 Хуудасны тоо : 1/1  
 Үр дүн :

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м <sup>3</sup>	Азотын давхар исэл мг/м <sup>3</sup>	Нийт Тоос /TSP/ мг/м <sup>3</sup>	Дуу чимээ /ДБА
1	Уурхайн карьер орчим	VI/12	14:20	0.012	0.021	0.120	46
2	Технологийн зам орчим	VI/12	15:05	0.013	0.027	0.146	52
3	Кемп орчим	VI/12	16:00	0.009	0.025	0.078	53
4	Нөхөн сэргээлт хийсэн талбай орчим	VI/12	17:05	0.011	0.026	0.095	50
Агаарын чанарын стандарт MNS 4585.2016 (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60

Шинжилгээ гүйцэтгэсэн:  
Агаарын хэсгийн инженер  
  
Хянаж баталгаажуулсан:  
Агаарын хэсгийн инженер



Э.Оюунтуяа  
Д.Түмэндэлгэр

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй

*Хавсралт 1 Агаарын чанарын шинжилгээ дүн (6 сар)*

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ  
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818  
E-mail: bphzti@gmail.com



**СОРИЛТЫН ДҮН**

Дугаар он/№ : 2022/A-233  
 Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Ногоон Эко Мандала"ХХК  
 Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : Б.Батхшиг агаарын хэсэг  
 Дээжийн тоо, төрөл : 4 агаар, 4 дуу чимээ  
 Сорьц авсан огноо : 2022.08.15  
 Дээжийн тодорхойлолт : Төв аймаг, Заамар сум, "Топ Ган Дриллинг"ХХК  
 MV-004411 лицензийн талбай  
 Шинжилгээний аргын стандарт : MNS 0017-2-5-12:2021, MNS 0017-2-5-11:2021  
 CA3 A07-2016  
 Шинжилсэн огноо : 2022.08.29  
 Хуудасны тоо : 1/1  
 Үр дүн :

№	Сорьц авсан цаг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м <sup>3</sup>	Азотын давхар исэл мг/м <sup>3</sup>	Нийт Тоос /TSP/ мг/м <sup>3</sup>	Дуу чимээ /ДБА/
1	Авто засвар орчим	VIII/24	12:45	0.010	0.023	0.075	56
2	Технологийн зам орчим	VIII/24	13:30	0.013	0.028	0.123	50
3	Уурхай орчим	VIII/24	14:20	0.009	0.027	0.097	54
4	Кемп орчим	VIII/24	15:00	0.007	0.021	0.068	52
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60

Шинжилгээ гүйцэтгэсэн:  
Агаарын хэсгийн инженер

Хянаж баталгаажуулсан:  
Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга




Д.Түмэндэлгэр

Б.Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй




*Хавсралт 2 Агаарын чанарын шинжилгээ дүн (8 сар)*

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ  
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Хавсралт 3 Ус ашиглах зөвшөөрөл

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “АР НАЙМГАН”-ЫН АЛТНЫ ГҮНИЙ  
ДАРАГДМАЛ ШОРООН ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

 <p>БАТЛАВ ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ</p> <p><i>[Signature]</i> Д.НЯМДОРЖ</p> <p>2022 оны 05 дугаар сарын 08</p>	 <p>БАТЛАВ "ТОП ГАН ДРИЛЛИНГ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ</p> <p><i>[Signature]</i> П.ГАНБОЛД</p> <p>2022 оны 05 дугаар сарын 08</p>
<p>УС АШИГЛАХ ГЭРЭЭ</p> <p>Дугаар УНТ 22/13</p> <p>Нэг. Ерөнхий зүйл</p> <p style="text-align: right;">Улаанбаатар хот</p>	
<p>Монгол Улсын Усны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт, "Усны газар"-ын 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 05/234 дугаартай албан бичгээр ирүүлсэн Дугаар 25 "Ус ашиглуулах дүгнэлт", Туул голын сав газрын захиргааны даргын 2022 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/6 дугаар тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:</p> <p>Ус ашиглуулагчийг төлөөлж Туул голын сав газрын захиргааны Уул уурхай, эрчим хүчний ус ашиглалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн П.Энхбаяр, Ус ашиглагчийг төлөөлж тусгай зөвшөөрөл эзэмшигч Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Эм Эс Эн Билдинг (MNS building), 604 тоот. Улсын бүртгэлийн 9011720069 тоот гэрчилгээ, 6268048 тоот регистрийн дугаартай "Топ ган дриллинг" ХХК-ийн Геологич О.Ганчимэг нар харилцан тохиролцож энэхүү гэрээг 2022 оныг дуустал байгуулав.</p>	
<p><b>Хоёр. Гэрээний гол нөхцөл</b></p>	
<p>2.1. <i>Ус ашиглах зориулалт:</i> Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-004411 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Ар Наймган" алтны шороон ордын технологийн болон бусад хэрэглээний усыг Туул голоос болон уурхайн шүүрэлтийн уснаас, хүн амын унд-ахуйн хэрэглээнд өөрийн эзэмшлийн худгаас усны нөөцийг ашиглана.</p> <p>2.1.1. Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 4.4-т заасны дагуу 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээж авах ажлын хэсэгт Туул голын сав газрын захиргаанаас төлөөлөл оролцуулж, дүгнэх хуудсыг баталгаажуулна.</p> <p>2.2. <i>Нийт ашиглах усны хэмжээ:</i> 81'840.0 м<sup>3</sup> элс угаах үйлдвэрлэл, технологийн болон бусад хэрэглээнд зарцуулах ус 107'304.0 м<sup>3</sup>/жил;</p> <p>2.2.1. Унд-ахуйд: 4'554.0 м<sup>3</sup>;</p> <p>2.2.2. Ашигт малтмал олборлон баяжуулах гадаргын ус 55'065.0 м<sup>3</sup>/жил</p> <p>2.2.3. Технологид шавхан зайлуулж ашиглах шүүрлийн ус: 47'685.0 м<sup>3</sup>/жил.</p> <p>2.3. <i>Усны чанар, найрлага:</i> 2022 оны 06, 09, 11 дүгээр сард хаягдлын нуурын уснаас дээж авч итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэн, шинжилгээний дүнг ус ашиглалтын тайланд хавсарган Туул голын сав газрын захиргаанд ирүүлнэ.</p> <p>2.4. <i>Усны эх үүсвэр:</i></p> <p>2.4.1. <i>Байршил:</i> Унд-ахуйн усны хэрэглээг 0.7 л/сек ундаргатай гүний худгаас /байршил 48° 18'21.46", 104° 26'08.27", технологийн хэрэглээний усыг Туул голоос болон уурхайн шүүрлийн шавхалтын усаар хангана.</p> <p>2.4.2. <i>Барилга байгууламж:</i> Бохир усны сан 46'200.0 м<sup>3</sup>, тунгаах сан 17'325.0 м<sup>3</sup>, цэвэр усны сан 27'180.0 м<sup>3</sup> эзлэхүүнтэй. Усан сангаас угаах төхөөрөмж рүү 150 мм голчтой, 130 м урт хоолойгоор ус татна.</p>	
	

Хавсралт 4 Ус ашиглах гэрээ

2

2.4.3. Тоног төхөөрөмжийн нэр, марк: DOOSAN DX 800 маркийн эксковатор 2 ш, Doosan DX 500 маркийн эксковатор 1 ш, Howo 371 маркийн автосамосвал 9 ш, KOMATSU D275 маркийн бульдозер 1 ш, DOOSAN SD300 маркийн утгуурт ачигч 2 ш, хоригт цорго (гравитаци) 1 ш, СКО-2 маркийн сэгсрэх ширээ (гравитаци) 1 ш, монгол СБ-60 маркийн хүрдэт шигшүүр 1 ш тус тус ашиглана.

2.4.4. Насосны хүчин чадал: Цэвэр усны сангаас угаах төхөөрөмж рүү Д-320-50 маркийн насосоор ус татна.

2.5. Хаягдал усны хэмжээ, стандартын шаардлага: Хаягдал усыг хүрээлэн буй орчинд нийлүүлэхдээ “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015” стандартын шаардлагыг мөрдлөг болгоно. Стандартаас давсан агууламжтай хаягдал усыг байгальд нийлүүлж буй тохиолдолд Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар батлагдсан “Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам”-ын дагуу төлбөр тооцно.

2.6. Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин:

2.6.1. Технологийн хаягдал усыг тунгаах нууранд тунгааж, эргүүлэн ашиглана. Стандартаас давсан агууламжтай хаягдал усанд Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар батлагдсан “Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам”-ын дагуу төлбөр тооцно.

2.6.2. Ахуйн бохир ус зайлуулах цэгийг Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд, Эрүүл мэндийн Сайдын 2018 оны А/82/128 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам”-ын дагуу тохижуулж ашиглана.

2.7. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:

2.7.1. Туул голоос ус татах насосыг байрлуулахдаа голын эрэг, голдирлыг хөндөхгүйгээр байрлуулна.

2.7.2. Усны эх үүсвэрийг хамгаалах усны нөөц хомсдох бохирдохоос сэргийлж жил бүр түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээг төсөвт суулган орон нутгийн захиргаа, байгаль хамгаалагчаас санал авч сэргээн засварлах шаардлагатай булаг шандыг тохижуулах.

2.7.3. Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг 5.0 га талбайд хийнэ.

